Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2021 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 2021.12.17

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Байгаль орчин, аялал жуулчлалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, бодлого боловсруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглуулах, нөхөн сэргээх, байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлал ногоон хөгжлийг дэлгэрүүлэх, салбарын чиг үүрэг бүхий байгууллагуудыг удирдлага арга зүйгээр хангахад эрхэм зорилго оршино.							
1	**Зорилт 1.** Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьчилан сэргийлэх, байгаль хамгаалах хууль тогтоомж, журмуудыг өрд иргэдэд сурталчлах гарсан зөрчлийг цаг тухайд нь таслан зогсоох ажлуудыг жилийн ажлын төлөвлөгөөнд тусганы дагуу, хөдөө сумдад дэс дараатай зохион байгуулж, гарсан хэрэг зөрчлийг орон нутгийн радио, хэвлэл мэдээллээр сурталчлах ажлыг сар бүр зохион байгуулна.						
1.1	Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор байгаль орчны салбар болон хууль хяналтын байгууллагуудыг нэгдсэн хяналт шалгалтыг хийх нөхцөлөөр хангах. /*хууль бус мод бэлтгэл, хууль бусаар ашигт*	1.0 сая	Байгаль орчныг хамгаалах тухай багц хууль тогтоомжийг сурталчилсан байна.	2020 онд Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор байгаль орчны салбар болон хууль хяналтын байгууллагуудыг нэгдсэн хяналт	Байгаль орчныг хамгаалах тухай багц хууль тогтоомжийг сурталчилсан байна	Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор байгаль орчны салбар болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран нэгдсэн хяналт шалгалтыг 4 удаа ажлын удирдамжын дагуу зохион байгуулаа. Үүнд Алтай Таван богдын байгалийн цогцолборт газрын Хотон нуур, Хуурган нуур, Даяннуур, Ховд	100%

	малтмал ашиглах, хулгайн ан, зохисгүй газар ашиглалт, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, мөн ойн нөхөн сэргээлт, хог хаягдал зөрчил гэх мэт бүх чиглэлээр/			шалгалтыг 10 удаа зохион байгуулсан		голын сав газрын дагуух, Алтанцөгц, Баяннуур сумуудын ойн сан бүхий газруудад хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг тус тус хийж гүйцэтгэв. Уг шалгалтын арга хэмжээний үеээр эрүүгийн хэргийн шинжтэй нэг зөрчил илэрүүлж аймгийн цагдаагийн газарт шилжүүлэн ажиллаа.	
1.2	Ой, ойн дагалт баялаг, байгалийн ургамал түүж бэлтгэж байгаа байдалд болон хууль бус ан агнуурт урьчилан сэргийлэх хяналт шалгалт хийж дэлхийд нэн ховор /Allum obligum/ ургамалд тооцогддог, улаан номонд орсон Алтайн зэрлэг сармисан сонгиныг ахуйн зориулалтаар түүж бэлтгэх гэмт хэрэг, зөрчлөөс		Тухайн гэмт хэрэг үйлдэхээс урьчилан сэргийлж, иргэд, олон нийт энэ гэмт хэргийн талаар ойлголтой болсон байна.	Монгол улсын Ерөнхийлөгчийн 2014 оны 48-р зарлиг, БОАЖСайдын 2014 оны А/297 тоот тушаалын биелэлтийг хангах, байгууллагын 2020 оны ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу МХГазар, ЦГазаруудтай	Байгаль орчныг хамгаалах тухай багц хууль тогтоомжийг сурталчилсан байна.	Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.12 дугаар заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд, Алтай сумын 2, 3, 4 дүгээр багийн хилийн бүсийн орчимд Хилийн 0165 дугаар анги, аймгийн Цагдаагийн газартай хамтран хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль сурталчлааны ажил болон хэлэлцүүлэг зохион	100%

	урьдчилан сэргийлэх чиглэлээр хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах.			хамтран Алтанцөгц, Ногооннуур сумдын ойн сав газрын нутгуудын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд БОХ тухай багц хуулийг сурталчилж мэргэжилийн арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.		байгуулан ажиллав.	
1.3	Байгалийн баялаг нөөц хамгаалах нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг чадавхжуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	3.0 сая	Нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа сайжирсан байна.	Ковид-2019 улмаас үйл ажиллагаа явагдаагүй болно.	Сургалтанд хамаарагдсан байна.	Ковид-2019 улмаас сургалтын үйл ажиллагаа явагдаагүй. Аймгийн хэмжээний агнуурын менежмент хариуцагч компаниудын санхүүжилтээр Бугат сумын “Тошинт”, “Төмөрт”, Улаанхус сумын “Агуйт-хатуу”, Дэлүүн сумын “Ахуунт”, Булган сумын “Улаагчин”, Алтанцөгц сумын “Мундуйн дэвсэг”, Баяннуур сумын “Уушигийн улаан”, Цэнгэл сумын “Борбургасан”агнуурын бүс	70%

						нутгуудад хариуцдаг нөхөрлөлүүдтэй хамтран зэрлэг ан амьтад өвс, хужир, давс тавих биотехникийн арга хэмжээний ажлуудыг зохион байгууллаа.	
1.4	Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод хяналт шалгал хийх, удирдлагыг мэдээллээр хангах		Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах орчин бүрдэнэ.	Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж хөтөлбөрүүдийн биелэлтийг БОАЖЯам, аймгийн ЗДТГазрын ХОХБТХ-д хүргүүлсэн байна.	Хууль тогтоомж, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангагдсан бана.	Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж хөтөлбөрүүдийн биелэлтийг цаг тухайд нь БОАЖЯам, аймгийн ЗДТГазрын ХОХБТХ-д хүргүүлэн удирдлагыг мэдээлэлээр ханган ажиллав. Үүнд: **1.**Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2018 оны 209 дүгээр тогтоол **2.**Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2019 оны 318 дугаар тогтоол **3.** “Хоггүй цэвэр Баян-Өлгий” дэд хөтөлбөр АИТХ-ын 2019 оны 88-р	100%

						тогтоол **4.** Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр ЗГ-ын 2014 оны 298-о тогтоол **5.**Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр БОАЖСайдын 2018 оны А/242 тушаал **6.** УЗОБ-ын үндэсний хөтөлбөр ЗГ-ын 2006 оны 99-о тогтоол **7.**АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ЗГ-ын 2017 оны 98-о тогтоол **8.** Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр ЗГ-ын 2011 оны 277 дугаар тогтоол **9.**Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр ЗГ-ын 2010 оны 90-р тогтоол **10.** Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр ЗГ-ын 2005 оны 44-р тогтоол **11.** Ус үндэсний хөтөлбөр	

						УИХ-ын 2010 оны 24-р тогтоол **12.**Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	
2. Ан амьтан байгалийн ургамлын нөөц, тархалтыг тогтоох, ашиглалтыг зохицуулах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, байгаль орчны цахим мэдээллийн системийн хэвийн ажиллагааг хангах.							
2.1	Биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.	5 сая	Ан амьтаны амьдрах орчин бүрдэж тоо толгой өснө.	7 агнуурын бүс нутаг болон менежментийг хариуцагч компаиудтай хамтран ангийн өвөлжилт хүндэрсэн бүс нутгуудад биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулсан.	Нэн ховор, ховор амьтны өвөлжилтийн байдал хүндэрсэн бүс нутагт биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Баян-Өлгий аймгийн Засаг даргатай 2021 онд Байгаль орчин, Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах №21-02 тоот гэрээ болон Амьтны аймгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 био техникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар заасны хүрээнд 5 сая төгрөг ний санхүүжилтээр Аргаль хонь, Янгир ямаа, Халиун буга зэрэг амьтны хаваржиж буй бүс нутаг болох Дэлүүн сумын “Хөх сэрх” ДЦГазар болон Улаанхус сумын “Баянзүрх” агнуурын бүс нутгийн “Харуул”, Толбо сумын “Хоторжон”, Ногооннуур сумын “Бахлаг” “Модон овоо”, Буянт сумын “Хаалгат” ангийн бүс	100%

						нутгуудад аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 27-ний ажлын удирдамжийн дагуу хужир, давс тавих био техникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлуудыг зохион байгуулав. Аймгийн хэмжээний агнуурын менежмент хариуцагч компаниудын санхүүжилтээр Бугат сумын “Тошинт”, “Төмөрт”, Улаанхус сумын “Агуйт-хатуу”, Дэлүүн сумын “Ахуунт”, Булган сумын “Улаагчин”, Алтанцөгц сумын “Мундуйн дэвсэг”, Баяннуур сумын “Уушигийн улаан”, Цэнгэл сумын “Борбургасан”агнуурын бүс нутгуудад хариуцдаг нөхөрлөл үүдтэй хамтран зэрлэг ан амьтад өвс, хужир, давс тавих био техникийн арга хэмжээний ажлуудыг зохион байгууллаа.	
2.2	Хугацаа дууссан болон шинээр хийлгэх агнуур зохион		Зүй зохистой ашиглах, ан амьтаны тоо	Хугацаа дууссан Буянт сумын Эзэрлэг ,	Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах.	Цэнгэл сумын “Борбургасан”, Буянт сумын “Эзэрлэг”, Дэлүүн сумын “Ахуунт”, “Улаан	100%

	байгуулалтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, агнуурын менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулах.		толгой, популяцийн зохион байгуулалт хийгдсэн байна.	шнээр Алтай сумын Цалгарын цагаан булаг, Ногооннуур сумын Хавцал, Баяннуур сумын Баяннуур агнуурын бүс нутгуудад ан амьтны мэргэжлийн байгууллагад агнуур зохион байгуулалт, ан амьтны менежментийн төлөвлөгөөг хийлгэх ажлыг зохион байгуулсан.		говь", Толбо сумын "Зурхайчин нуруу", Алтанцөгц сумын "Мундуйн дэвсэг", Баяннуур сумын "Уушигийн улаан" зэрэг агнуурын бүс нутгуудын ан агнуурын менежментийн төлөвлөгөө, нарийвчилсан агнуур зохион байгуулалтыг Агнуур судлалын нийгэмлэг төрийн бус байгууллага шинээр Цэнгэл сумын Баянцэнгэл ангнуурын бүс нутагт нарийвчилсан агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг Авралын эрэлд ХХК-д тус тус гүйцэтгүүлэв.	
2.3	Жил бүр тусгай болон ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих амьтан ургамлын захиалгыг холбогдох газарт хүргүүлэх, нөөц ашигласны төлбөрийн орлого бүрдүүлэлтэд	Хувийн хэвшлийн төсөв	Дараах онд тусгай, үйлдвэрлэлийн, ахуйн зориулалтаар агнах барих амьтан, ургамлын саналыг	Дараах жил агнах барих, ахуйн, үйлдвэрлэлийн, тусгай зориултаар ан амьтны саналыг хугацаанд БОАЖЯаман	Хугацаанд саналыг БОАЖЯаманд хүргүүлж, батлуулан орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлнэ.	Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын дөрөвдүүгээр хэсэгт заасны дагуу хугацаанд аймгийн хэмжээний агнуурын бүс нутгуудаас тусгай, ахуйн	100%

	хяналт тавих		холбогдох байгууллагад хүргүүлж, нөөц ашигласны төлбөрийн орлогод хяналт тавих орчин бүрдэнэ.	д хүргүүлж, нөөц ашигласаны төлбөрийн оролгод хяналт тавьж, тайланг БОАЖЯаманд хүргүүлсэн.		болон үйлдвэрлэлийн зориулалтаар 2022 онд агнах барих ан амьтны саналыг БОАЖЯамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газарт хүргүүлэв.	
2.4	Иргэдийг ан амьтныг хамгаалах үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах		Залуу хойч үед байгаль хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах ажлыг зохион байгуулан.	Иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтныг хамгаалах үйл ажиллагааг цахим мэдээллийн хэрэгцлээр сурталчлах ажлыг сар бүр зохион байгуулав.	Амьтныг хамгаалах үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах.	Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг “Таны дуу хоолой байгалийг хамгаалж чадна” уриа дор “Ногоон дуу хоолой” сарын аян, дэлхийн байгаль хамгаалах өдрүүдийг тэмдэглэн өнгрүүлэх болон байгаль орчны багц хуулиудыг орон нутгийн радио, хэвлэл, телевизээр сурталчилах, батлагдсан ажлын төлөвлөгөөний хүрээнд амьтны болон байгалийн ургамлын тухай хууль тогтоомжуудыг орон нутгийн радио телевизээр сурталчлах ажлыг 12 удаа зохион байгуулаа.	100%
3. Усны нөөцийг хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах							
3.1	Усны тухай хуулийн		Ус	ус	хуулийн дагуу	Усны тухай хуулийн 28,4-т	

	дагуу иргэн аж ахуйн нэгж байгууллагуудад ус ашиглуулах дүгнэлт гаргаж, гэрээ байгуулах, иргэн аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу ундны болох ахуйн худаг гаргах зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах		ашиглуулах дүгнэлт, гэрээ, зөвшөөрөлий г хууль журмын дагуу хурдан шуурхай хийж биелэлтэнд хяналт тавин ажилах.	ашиглуулах 17 дүгнэлт, гэрээ 6, худаг өрөмдөх зөвшөөрөл 1 олгогдсон.	ус ашиглуулах дүгнэлт гаргаж, гэрээ хийж, худаг өрөмдөх зөвшөөрөл олгогдсон байна	заасны дагуу Өлгий сумын 9-р багт үйл ажиллагаа явуулдаг “Ахжол” халуун усны газар, Жанат ХХК-ны Дэлүүн, Улаанхус сумуудад үйл ажиллагаа явуулдаг нэгдсэн халаалтын зуух, Алтанцөгц сумын “Ямаат” нэртэй газарт хайгуулын үйл ажиллагаа явуулдаг “Түвшингарав” ХХК, Буянт сумын төвд үйл ажиллагаа явуулдаг “Бөртеш” хоршооны тоосго, стандарт блокны цех, Бугат сумын төвд үйл ажиллагаа явуулдаг стандарт блокны цех, Сагсай сумын төвийн аж ахуйн нэгжүүдийг дулаанаар хангаж буй “Каде ХХК” Өлгий сумын 6-р багт үйл ажиллагаа явуулдаг “Гүлим ” халуун усны газар, Өлгий сумын 13-р багт үйл ажиллагаа явууулдаг “Тэнэгэр Алтан тоосго ” ХХК, Цэнгэл сумын 8-р багт үйл ажиллагаа явуулдаг “Цэнгэл тоосго” ХХКомпаниудын 2021 онд ус ашиглуулах дүгнэлтүүдийг тус тус гаргаж зохих газарт нь хүргүүлэн ажилласан. Усны тухай хуулийн 28.6 -т заасны дагуу “Эрчим ХХК”,	100%

						“Хотгор Зам” ХХК, “Эйш кей би” интернэйшнэл колдинг ХХК, “Нью констракшн” ХХК, “Азат” ХХК, “Угр” ХХК-ын 2021 онд ус ашиглуулах дүгнэлтүүдийг үндэслэн ус ашиглах зөвшөөрөл олгож, ус ашиглах гэрээ байгуулан усны нөөц ашигласны төлбөр ноогдуулж ажиллаж, Усны тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 1.6, 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг үндэслэн Бугат сумын 3 дугаар багт орших хүүхдүүдэд унд ахуйн зориулалтаар гүний худгийн нэг цооног гаргах хүсэлтийн дагуу цооног өрөмдөх зөвшөөрөл олгож гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллаа.	
3.2	Аймгийн төвийн 20-50 км тойрогт, сум, суурин газруудад 10 км тойрогт, баг, хот айлд 5 км-ийн тойрогт орших гол, мөрөн, нуур, цөөрөм, булаг, шанд, уст цэгүүдийг ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлаас	Сумдын ЗДТГ	Гол горхи булаг шандын эхийг цэвэрлэх ажлыг зохион байгуулах.	2, 3 удаа цэвэрлэгээний ажил хийгдсэн	гол горхи булаг шанд уст цэгүүд 2, 3 удаа цэвэрлэгээ хийгдсэн байна	Аймгийн хэмжээнд 2021 оны 5,10-р саруудад аймгийн төвд 15-20 км тойрогт, сумдад 8-10 км тойрогт, баг хот айлд 5 км-ийн тойрогт орших гол мөрөн, нуур цөөрөм, булаг шанд, уст цэгийг ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлаас цэвэрлэх, байгалийн голдирлыг сэргээх, тохижуулах, хамгаалах арга хэмжээнд нийт давхардсан	100 %

	цэвэрлэх, голын голдиролыг нь сэргээх, тохижуулах, хамгаалах арга хэмжээг нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг оролцуулан жилд 2 удаа зохион байгуулах					тоогоор 1927 иргэдийг оролцуулан 46 гол, 8 нуур, 34 булаг шанд, 5 рашааны эхийг цэвэрлэн 36,4 тонн ил задгай асгасан эзэнгүй хуурай хог хаягдал, малын үхсэн сэг зэмийг ачин төвлөрсөн хогийн цэгт хүргэх ажлыг зохион байгууллаа.	
3.3	Дэлхийн усны өдрийг угтан холбогдох байгууллагуудтай хамтран сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах.	60.0 мянган төгрөг	Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх.	1 удаа хийгдсэн	Дэлхийн усны өдрийг угтан 1 удаа сургалт явуулсан байна	Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа, Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа мөн НААҮйлчилгээний “Су ат”ХХКомпани, Баян-Өлгий аймгийн байгаль хамгаалах иргэний салбар зөвлөлтэй хамтран Дэлхийн байгаль хамгаалах сангийн /WWF/ санхүүжилтээр “У СНЫ ҮНЭЛЭМЖ” /усны үнэ цэн / сэдвээр Баян-Өлгий аймгийн хэмжээнд хамтарсан төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг зохион байгууллаа. Усны үнэ цэнэ, усны нөөц,	100%

						усны зүй зохистой хэрэглээ зэрэг мэдээллээр хангах үүднээс 3 дугаар сарын 17-ний өдөр орон нутгийн хэвлэл мэдээллийн “Дербес”, “Саян” телевизүүдээр дугуй ширээний хэлэлцүүлэгт зохион байгуулав. Аймгийн хэмжээний Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд “Усны үнэлэмж” сэдвээр 1-5 дугаар ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан, 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд зохион бичлэгийн уралдаан, 10-12 дугаар ангийн сурагчдын дунд Эсээ бичлэгийн уралдаан тус тус зохион байгуулав. Өлгий сумын ЗДТГ-ын Хот тохижуулах албатай хамтран усны сан бүхий газар, уст цэгийн орчмын ахуйн хогийг цэвэрлэх, ажлыг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд, МАНУТХГХЗ, Хот тохижуулах алба ХНХГСГЗ-ны нийт 70 гаруй ажилчид ороллоо. Орон нутгийн хэвлэл	

						мэдээллийн хэрэгсэл, TV-гээр болон цахимаар дамжуулан богино хэмжээний видео, шторк бэлтгэж, м эдээлэл түгээх ажлыг зохион байгуулав.	
3.4	Аймгийн хэмжээний гадаргын усны тооллого явуулах ажлыг зохион байгуулах.	Орон нутгийн төсөв	Усны тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	1 удаа тоо бүртгэлийн ажил хийгдсэн	тоо бүртгэлийн ажил үнэн зөв 1 удаа хийгдсэн байна	2021 оны гадаргын усны тоо бүртгэлийг сум тус бүрээр зохион байгуулав. Үүнд аймгийн хэмжээнд Булаг шанд 954, Гол горхи 418, нуур тойром 1246, 31 рашаан, гар худаг 5950, гүн өрмийн худаг 538, ширгэсэн булаг шанд 7, нуур тойром 3, гол горхи 4, ундарга нь багассан булаг шанд 9, нуур тойром 12, гол горхи 3 тус тус тоологдсон байна.	100%
3.5	Булаг шандын эхийг хамгаалалтанд авч тохижуулах ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв болон БОАЖГ 6.0 сая	Усны зүй зохистой ашиглалт бий болсон байна.	Цэнгэл, Сагсай, Буянт сумдад тус бүрт 1 ширхэг булаг хамгаалагдсан	3 булаг шандын эх хамгаалагдсан байна.	Дэлүүн, Толбо, Булган сумдын нутаг дэвсгэрт тус бүр 1 булаг, шандны эхийг хашиж хамгаалах ажлыг “Хотын цамхаг” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж аймгийн ажлыг хэсэг хүлээн авч орон нутагт хүлээлгэж өгөв.	100%
3.6	Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн, дэглэмийг	Холбогдох байгууллагууд	Эрүүл ахуйн шаардлага хангасан гүний	4 удаа цэвэрлэгээний ажил хийлгүүлж бүсийн	4 удаа цэвэрлэгээний ажил хийгдэж Эрүүл ахуйн	Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх зорилгоор Суат ХХК –д шаардлага хүргүүлж, цэвэрлэгээний ажлыг 4 удаа	100 хувь

	мөрдүүлэх		худгуудтай болно.	дэглэмийг мөрдүүлсэн	бүсийн дэглэм мөрдөгдсөн байна	хийлгүүлж ажилласан.	
3.7	Баян-Өлгий аймгийн усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоох асуудлыг шийдвэр гаргуулан батлуулах		Тогтоол гаргуулсан байна.	2020 онд ИТХуралд оруулж шийдвэрлүүлээгүй болно.	Хамгаалалтын бүсийг тогтоосон байх	Аймгийн Засаг даргын 2021 оны А/129 дүгээр захирамжаар аймгийн нийт нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийг тогтоох санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Уг захирамжийн дагуу 2021 оны 11-р сарын 03 ны өдөр Хар нуур – Ховд голын сав газрын захиргаатай хамтран бүх сумдын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарыг оролцуулан санал боловсруулах сургалтыг зохион байгуулж ажилласан. 2021 оны 12 дугаар сарын 01 ний өдөр болсон ИТХ-ын ээлжит зургаадугаар хуралдаанд Хар нуур Ховд голын сав газрын захиргаатай хамтран бичиг баримтуудыг бүрдүүлэн оруулсан боловч 97% саналаар дэмжигдсэнгүй.	100%
4. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа, үйлдвэрлэл явуулдаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг БОНБЕҮнэлгээнд							

хамааруулан, шаардлагатай аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьж ажиллах.							
4.1	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг БОНБҮнэлгээнд хамруулах		Байгууллага, аж ахуйн нэгжүүд БОНБҮнэлгээнд хамрагдсан байна	2020 онд нийт 98 аж ахуйн нэгжийг БОНБҮнэлгээнд хамруулсан	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг орон нутгийн хэвлэл мэдээллээр болон аж ахуйн нэгжүүдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, 2021 онд нэг аж ахуйн нэгжид Нарийвчилсан үнэлгээнд хамааруулах ба 226 иргэн, аж ахуйн нэгжийн төсөлд БОНБЕҮнэлгээний дүгнэлт гарган ажиллаа. БОНБҮ-д хамаарагдсан иргэн, ААН байгууллагуудын үнэлгээний мэдээлэлийг БОАЖЯ-ны БОНБҮ-ний мэдээлэлийн санд бүрэн оруулав.	100%
4.2	Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгуулагуудын тухайн онд хэрэгжүүлэх байгаль орчны хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.	Хувийн хэвшлийн төсөв хөрөнгөөр	Ажлын гүйцэтгэл сайжарсан байна	2020 онд 10 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн Байгал орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж	Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт биелэгдсэн байна.	БОАЖСайдын 01/4759 зөвлөмжийн дагуу Цэнгэл суманд байрлах алтны үндсэн ордын баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж, баяжуулах үйлдвэрт натри цианид ашиглах үйлдвэрийн технологи, химийн хорт болон аюултай бодисын хадгалах агуулах зэрэг ажлуудыг газар дээр нь	100%

				ажилласан		танилцах ажлыг аймгийн МХГазар, ОБГазар, ЦГазар хамтран зохион байгуулж, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 6 Аж ахуй нэгжийн мененжментийн төлөвлөгөөний биелэлтэнд хууль хяналтын байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажилласан.	
4.3	Уул уурхайн үйл ажиллагааны уулмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэх	Хувийн хэвшлийн төсөв хөрөнгөөр	Нөхөн сэргээлтийн ажлын 60 дээш хувьд хүрсэн байна.	2020 онд уул уурхайн улмаас эвдэрсэн 2.1 га газарт нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэсэн	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Аймгийн Засаг даргын захирамжаар “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн засаг даргын А/570 дугаар захирамжаар байгуулан нөхөн сэргээлтийн ажлын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Ногооннуур суманд бичил уурхай эрхэлдэг ASM00012 тусгай зөвшөөрөлтэй “Сунхар” нөхөрлөлийн олборлолт явуулсан 0.4 га газарт нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэж, Алтай сумын энгэрт нэртэй талбайн Сагсай минерал ресурс ХХК-ны 4.8 га, Булган сумын хуурай салаа нэртэй	100 %

						талбайн Бүркит корпорацийн 24.3 га газарт нөхөн сэргээлтийн ажлыг хийх тухай МХГ-ын Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлээд байна.	
5. Орчны бохирдлын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах							
5.1	Холбогдох байгууллагуудтай хамтарч хууль, тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах, эрүүл ахуйн орчныг сайжруулах, орчны бохирдлыг багасгах зорилгоор аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтын ажил зохион явуулах.	----	Орчны бохирдол багассан байна.	Өлгий хотын орчны эрүүл ахуйн нөхцөл ийг хангуулах ажлын төлөвлөгөө гаргаж ажилласан байна.	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Орчны бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх, судалгаа хийх зорилгоор Өлгий сумын Засаг даргатай хамтарсан удирдамж гаргуулсан. Уг удирдамжийн дагуу Өлгийн төвд үйл ажиллагаа явуулдаг 49 аж ахуйн нэгж, байгууллагуудад МХГазрын улсын байцаагч болон Өлгий сумын байгаль хамгаалагч нартай хамтарч хяналт шалгалт хийв. Шалгалтын явцад ихээхэн газарт ангилан ялгах стандарт шаардлага хангасан хогийн сав байхгүй, зарим газрууд үнс болон хог хаягдлыг	100%

						хашааны дотоор ил задгай хаядаг зөрчлүүд илэрсэн. Зөрчил гаргасан газруудад зөрчлүүдээ арилгуулах зөвлөлгөө өгч, агаар, хог хаягдлын хууль тогтоомжуудыг сурталчилж ажиллав. Үүнд: 1. Бүх аж ахуйн нэгж, байгууллагууд орчин тойрноос 50 метрийн радиустай газрын хог хаягдлыг байнга цэвэрлэж байх. 2. Ангилан ялгах стандарт шаардлагад нийцсэн хогийн савтай болох. 3. Өдөр тутамд гарч байгаа дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг цуглуулж хотод ачуулж байгаа “Музды-тау” ХХКомпанид хүлээлгэж өгөх. 4. Ил задгай хог шатаахгүй байх, 4. Үнс хадгалах газрыг битүүлэх, 5.Зууханд шүлтүүр тавиулах, 6. Нэгдсэн халаалтанд холбох боломжтой газруудыг нэгдсэн хаалалтанд холбох зэрэг шаардлагуудыг тавьж	

						ажилласан. Уг шаардлагуудыг 13 аж ахуйн нэгж, байгууллагууд биелүүлж ангилан ялгах стандарт шаардлагад нийцсэн хогийн савтай болсон байна.	
5.2	Байгальд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг зүй зохистой хаях, ангилах, дахин ашиглах дадал зуршлыг төлөвшүүлэх, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар хэвлэл мэдээллээр сурталчлах	Төсөл хөтөлбөр	Хог хаягдлыг ангилан ялгаж хаях, хог хаягдлын байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учруулах хор нөлөөллийн талаар мэдээлэлтэй болно	Холбогдох төрийн болон ТББ байгууллага, Байгаль хамгаалагч, Улсын байцаагч, ЕБДСургуулийн сурагч нарт сургалт сурталчилгаа 3 удаа зохион байгуулав.	Сургалт, сурталчилгааны ажил явагдсан байна	“Хог хаягдлын өнөөгийн байдал, хор уршиг ба цаашид авах арга хэмжээ” сэдэвт сургалтыг аймгийн Улаанхус сумын Хөх хөтөл багт МАНУТХГХЗахиргааны мэргэжилтэнтэй хамт зохион байгуулав. Тус багт хог хаягдлыг ангилан ялгах нөхцөл бүрдсэн ба иргэдэд хог хаягдлын тухай хууль, хог хаягдлыг багасгах, ангилан ялгах, эргүүлэн ашиглах талаар ойлголт өгөв. Сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 63 сурагч, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, хүн эмнэлэгийн 42 албан тушаалтан оролцов. Сургалтад хамрагсад хогийг ангилан ялгах аяныг эхний ээлжид ерөнхий боловсролын сургуульд	100%

						хэрэгжүүлэн үр дүн ард иргэдэд танилцуулахаар тохиролцов.	
5.3	Бүх сумуудад хог хаягдлын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоож ИТХ-д оруулж батлуулах арга хэмжээ авах	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хог хаягдлын асуудлыг шийдэх санхүүгийн эх үүсвэр бий болно	Алтай, Алтанцөгц сумууд хог хаягдлын хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоосон байна.	Хууль ,журмын хэрэгжилт хангагдсан	Тухайн жилд хог хаягдлын төлбөрийн хэмжээг Өлгий, Дэлүүн, Цэнгэл, улаанхус, Аотай, Бугат сумууд шинээр тогтоолгож батлуулан мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.	70%
5.4	Орчны бохирдлын эх үүсвэрүүдийн тооллогыг аймгийн хэмжээнд холбогдох байгууллагуудтай хамтарч зохион байгуулж зохих газруудад хугацаанд тайлагнах	Орон нутгийн төсвөөр	Агаар орчны бохирдуулагчийн судалгаа бий болно.	2019 оны орчны бохирдуулагчийн судалгаа хийгдсэн болно	Орчны бохирдлын эх үүсвэрүүдийн тооллого хийх	Монгол улсын “Агаарын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2018 оны А-479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ыг үндэслэн, Аймгийн засаг даргын “Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах тухай А/957 “Ажлын хэсэг томилох тухай” захирамж, аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны	100 %

						“Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого зохион байгуулах тухай” албан тоотын дагуу уг ажлыг зохион байгуулж тооллогын мэдээллийг нэгтгэн боловсруулан тайланг зохих газруудад тайлагнав.	
5.5	Олон нийтийг хамарсан их цэвэрлэгээний ажлыг холбогдох байгууллагуудтай хамтарч зохион байгуулах	-	Эзэнгүй хог хаягдал хаясан газруудын судалгаа гарсан байна.	Жил бүрийн 4 улиралд нийтийн цэвэрлэгээ хийгдсэн байна	Эзэнгүй хог хаягдал багасна	Өлгий сумын ЗДТГазартай хамтарч аймагт орж гарах 6 чиглэлд 3 удаа цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан. Уг цэвэрлэгээнд нийт 81 аж ахуйн нэгж, байгууллагууд оролцож, 40 гаруй тн эзэнгүй хог хаягдлыг ачиж хогийн цэгт буулгасан болно. Мөн аймгийн төвийн бүх аж ахуйн нэгж, байгууллагууд сар бүр өөрсдийн эзэмшлийн 50 м газрын орчин тойронг цэвэрлэсэн. Ковид-19 үед зарим арга хэмжээг хязгаарласан. Өлгий сумын Хот тохижуулах алба тогтмол Өлгий доторхи хар зам дагуу болон нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэдэг бол СӨХ-ийн	100%

						ажилтнууд хагас жилийн хугацаанд орон сууцнуудын 1056 тн хог хаягдлыг ачиж хогийн цэгт буулгаж ажилласан байна.	
5.6	Өлгий сумын агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, түүнд мөрдөх журмыг баталж, хэрэгжүүлэнэ		Журам боловсруулсан болно.	ИТХ-д санал оруулан батлуулах		Өлгий сумын агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоох журмыг боловсруулж батлуулхаар БОАЖЯаманд хүргүүлсэн болно.	100%
5.7	Аймаг болон сумын төвүүдийн бүх байгууллага, ААН-ийг стандартын шаардлага хангасан нэг загварын ангилан ялгах, хогийн савтай болгох арга хэмжээ авна		Стандарт шаардлага хангасан хогийн савтай болно.	Өлгий сумын 12, 8-р багийн нутаг дэвсгэрт 15 ширхэг ангилан ялгах хогийн сав байршуулсан байна.	Хогийн ангилан ялгах савтай болсон байна.	Өлгий сумын ЗДТГазарт ангилан ялгах хог хаягдлын савд тавигдах стандартын дагуу хийлгэх талаар хүсэлтийг хүргүүлж мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. Уг хогийн савуудыг Хятад улсад хийлгэж байгаа болно.	70%
6. Газрын хэвлийн талаар төрөөс баримтлах бодлого							
6.1	Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн ажлын чанар, стандарт, гүйцэтгэл, иргэд, хуулийн этгээдийн санаачлагыг дэмжиж орон нутгийн	Сумдын ЗДТГ	10 га эвдэрч эзэнгүй орхигдсон газарт техникийн нөхөн сэргээлт хийлгэх	2020 онд аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны улмаас эвдэрсэн 4.6 га газарт	Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт сайжирсан байна.	Цэнгэл сумд “Цэнгэл тоосго” ХХК 0,5 га шар шавар олборлосон газарт 250.000 төгрөгөөр, Буянт сумд “Нур едил” ХХК нь 1 га хайрга олборлосон газарт 1 сая төгрөг Алтанцөгц сумын иргэн Б.Кешилик 0.5 га газрыг 250 мянган төгрөг, Ногооннуур сумын ЗДТГ 1	100%

	холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэн ажиллах.			4.150.000 төгрөгөөр техникийн нөхөн сэргээлт хийгдлээ.		га газрыг 150 тянган төгрөг, Дэлүүн сумд Едилжайых ХХК 1 га газрыг 2 сая төгрөгөөр тус тус техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 4.6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ.	
6.2	Газар нутгийн орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан тухай шийдвэрээ, холбогдох мэдээллийн хамт БОАЖ-ын яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлэн шийдвэр гаргуулах арга хэмжээ авч ажиллах.	Төсөв хөрөнгөөр	Орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан шийдвэрээ холбогдох газруудад хүргүүлэх	материалыг Ашигт малтмал газрын тосны газарт хүргүүлсэн боловч, зарим материал дутуу, координат буруу гэсэн шалтгаанаар орон нутгийн тусгай хамгаалалтанд авагдаагүй болно	200.000 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах арга хэмжээ авагдсан байна.	Аймгийн ИТХ-ын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 20 дугаар тогтоолоор Бугат сумын Саят Толгой 8,6 га газар, Алтанцөгц сумын Цамбагарав уул 63 га газар, Улаанхус сумын Тахилгат толгой 0,59 га газруудыг аялал жуулчлалын түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах зориулалтаар 20 жилийн хугацаатай орон нутгийн тусгай хэрэгцээнд хамруулав. Аймгийн ИТХ-ын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор 2016 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 70 дугаар тогтоолоор баталсан орон нутгийн тусгай	70%

						хамгаалалтанд авсан газруудын тусгай хамгаалалтанд байх хугацааг 15 жилээр сунгав.	
6.3	“Ногоон паспорт” аяныг ерөнхий боловсролын сургуулиудын эко клубуудын сурагчдыг хамруулан хэрэгжүүлэх.	Байгуулл агын төсвөөр	Сургалт, сурталчилгаа ны ажил зохион байгуулагдса н байна.	Сургалт 1 удаа, сурталчилгаа ны ажлыг ногоон паспорт эзэмшигч эко клуын сурагчдын нэгдсэн группт, БОАЖГ-ын фейсбук хаягаар сурталчилан ажиллав.	5-аас доошгүй удаа сургалт, сурталчилгааны ажлыг улирал бүр зохион байгуулагдсан байн	Коронавирус халдварт өвчинтэй холбоотой сурагчидтай хамтран ажиллах боломжгүй байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний нээлтэд эко клубын сурагчид оролцож, өөрсдийн санаа бодлоо илэрхийлж, “Ногоон паспорт-ногоон төгөл” цэцэрлэгт хүрээлэнд ногоон паспорт эзэмшигч сурагчид мод тарьлаа. 9-р сарын 6,7,8-ны өдрүүдэд Цагааннуур, Ногооннуур, Алтанцөгц, Баяннуур сумдын сургуулийн захирал нартай уулзаж эко клубуудыг эко сургууль болгох дэд хөтөлбөр боловсруулах талаар санал солилцох сурталчилгааны ажлыг зохион байгуулав.	90%
6.4	Газрын тухай хууль, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын нутгийн тухай тогтоомжийг орон		Сурталчилгаа ны ажил зохион байгуулах	Орон нутгийн телевизээр 1 удаа ярилцлага, орон нутгийн	4-аас доошгүй удаа сурталчилгааны ажил хийгдсэн байна.	Эко клубын үйл ажиллагаа, орон нутгийн тусгай хамгаалалтанд газар нутгийг хамруулахад анхаарах зүйлийн тухай,	70%

	нутгийн радио, телевизээр сурталчилгааны ажил зохион байгуулсан.			радиогоор 3 удаа мэдээ өгч сурталчилсан, мөн байгууллагын фэйсбүүк цахим хуудсанд 5 удаагийн мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг түгээж ажилласан.		орон нутгийн радиогоор газрын хэвлийн тухай болон хуулийн тус тус сурталчилах ажлыг 4 удаа зохион байгуулав.	
7. **ОЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР**							
7.1	Аймгийн хэмжээний болон Ойн сан бүхий 10 суманд ойн менежментийн төлөвлөгөөг гүйцэтгэх ажлыг зохион байгуулах.	13.0	Ойг хамгаалах зүй зохиостой ашиглагдсан байна.	2017 онд ойн менежментийн төлөвлөгөө хийгдсэн	Аймгийн хэмжээнд менежментийн төлөвлөгөө хийгдсэн байна.	Орон нутгийн төсвийн 13.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ойн сан бүхий 10 сум болон аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг “Мөнх ногоон жодоо” ХХК гүйцэтгэж ойн менежментийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргад баталуулж, хянан шалгаж хүлээж авлаа.	100%
7.2	Урд онуудад хийгдсэн ойжуулалтын ажлын арчилгаа усалгааны	5.7 сая төгрөг	Ойн зурвасын ургалтан 85 дээш	19 сая төгрөгөөр усалгаа арчилгаанд зориулж 3	10 га талбайд ойн зурвас байгуулж, 85 дээш амьдралтнь хувьтай	Урд онуудад хийгдсэн ойжуулалтын ажлын арчилгаа усалгааны ажлыг гүйцэтгүүлэхээр Сум дундын ойн ангитай гэрээ	100%

	ажлыг шийдвэрлэх		амьдралтын хувьтай болсон байна	худаг гаргасан.	байна	байгуулан онгоцны буудал явах хатуу хучилттай авто зам дагуу байгуулсан ойжуулалт, ойн зурвас болон Өлгий-Толбо чиглэлийн 10 га Ногоон хэрмийн ойн зурвас, Шинэ онгоцны буудал явах зам дагуу байгуулсан ойн зурвас, БОАЖГазрын ойн зурвас байгуулсан 3.5 га талбайд тус тус усалгаа арчилгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.	
7.3	Ойг нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойжуулах ажлын хүрээнд Өлгий сумын ногоон хашааг шинэчлэн сайжруулах, нөхөн тарилт хийх	10.0 сая төгрөг	45.6 га талбайн хашааг сайжруулах, 5 га талбайд нөхөн тарилт хийнэ	2020 онд Өлгий сумын 10-р багт 5 га газарт ойжуулалт хийгдсэн	Өлгий сумын ногоон байгууламж сайжарсан байна.	Өлгий сумын мод тарьсан ногоон хашааг шинэчлэн сайжруулах зорилгоор Өлгий сумын ЗДТГ-ын Хот тохижуулах албатай гэрээ хийж үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаа. Мөн БОАЖГ-ын харьяанд байгаа Ногоон паспорт-Ногоон төгөл” цэцэрлэгт хүрээлэнгийн хашаанд гоёлын болон жимсний 570 ширхэг суулгацыг худалдан авч тарьж арчилан хамгаалж ургуулж байна. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгөөр Өлгий сумын ногоон хашааг засварлах ажил хийгдэв.	100%

7.4	“Ногоон паспорт-Ногоон төгөл” цэцэрлэгийг ажлыг өргөжүүлэн мод тарих ажлыг зохион байгуулах	6.0 сая төгрөг	3.0 га –аар өргөжүүлнэ	2020 онд ногоон төгөл цэцэрлэгт хүрээлэнд 2500 ширхэг гоёл, жимсний 9 төрлийн мод таригдсан.	Ногоон төгөл хашаанд мод таригдаж арчилгаа хамгаалалтхийгдэж байна.	Ногоон паспорт-Ногоон төгөл” цэцэрлэгт хүрээлэнгийн 3.5 га газарт урд онуудад болон энэ жилд таригдсан нийт 5000 ширхэг гоёлын болон жимсний моднуудыг усалгаа хийх зорилгоор худаг гаргаж ашиглалтад оруулан усалгаа хийж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Баян-Өлгийчүүд бид 10 жилийн хугацаанд 20 сая мод тарьж ургуулахаар уриалга гарган ажиллаж, энэ хүрээнд эрдэмтэн мэргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн төлөөлөл болон эко клубын сурагчдын оролцоотойгоор мод тарьж ургуулах түүний арчилгаа хамгаалалтын талаар сургалт семинар зохион байгуулав. Сагсай сумын Улаан дэл гэх газарт мод услах ажил орон нутгийн	100%

						санхүүжилтээр 6 сая төгрөгөөр энгийн худаг гаргуулж усан хангамжийг нэмэгдүүлэх ажил хийгдсэнээр 20 га талбайг усаар хангах боломж бүрдэж 20 га талбайн усалгаа хэвийн явагдах боломж бүрдсэн болно. Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахад бүх нийтийн оролцоог нэмэгдүүлж , ойжуулалт, таримал ойн төгөл байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг дэлхийн дунджид хүргэнэ” гэсэн зорилготой 2022 оноос 2030 он хүртлэх 8 жилийн хугацаанд хэрэгжих “Ногоон Өлгий” дэд хөтөлбөр хийж аймгийн ИТХ-ын ээлжит хуралданаар оруулан батлаулав.	
7.5	Мод үржүүлгийн газрын бүртгэл, тооллогын ажлыг Ойн бодлого зохицуулалтын	Улсын төсөвийн хөрөнгөөр	Ажлыг зохион байгуулж тайланг 6 дугаар сарын 20-ны дотор танилцуулсан	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж,	Мод үржүүлгийн талбайн тарьц суулгацын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор мөчир тарих газрын хөрс боловсруулалтын ажлуудыг хийж 40.000	70%

	газартай хамтран зохион байгуулах		байна	нэгж, байгууллагын бүх мод үржүүлгийн газар хамрагдсан байна.	байгууллагын бүх мод үржүүлгийн газар хамрагдсан байна.	гаруй ширхэг улиас, бургас модны мөчир тарих ажлыг хийж гүйцэтгэсэн, ургалт нь 95-аас дээш амьдралтын хувьтай байна. Мөн Хөх Сэрхийн нурууны УТХГ-ын хамгаалалтын захиргааны мод үржүүлийн талбайгаас нийт 800 ширхэг бургасны тарьц бэлдэж Дэлүүн сумын төрийн болон төрийн бус байгууллага айл өрхүүдийг тарьцаар хангав.	
7.6	Бүх нийтээр мод тарих аяныг зохион байгуулж тарьсан модны арчилгаа хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулах, тайлагнах	Улсын төсөвийн хөрөнгөөр	50000 дээш ширхэг мод ургуулсан байна.	2020 онд 112190 ширхэг 2 төрлийн мод таригдсан	Хавар намрын мод тарих өдрийг зохион байгуулсан байна	Аймгийн Засаг дарга болон "Цэвэр-Ногоон-Өлгий", УИХ-ын гишүүн Т.Аубакирийн санаачилсан "Ногоон Өлгий" аяны хүрээнд "Хог биш мод тарьж, ногоон Өлгийг хамтдаа бүтээцгээе" уриан доор “Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах тухай” төлөвлөгөө гаргаж, аймгийн Засаг даргын А/443 тоот захирамжаар батлуулан төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулав. Монгол, казах хэлээр орон нутгийн радио, тэлэвиз хэвэл мэдээлэлээр сурталчилгаа явуулаж, мод тарих	100%

						аргачлалтай брошур хийж ард иргэдэд тараав. Сумдаар явж мод тарих ажлыг газар дээр нь заавар зөвлөмж өгч ажиллаа. Аймгийн Засаг даргын 2021 оны А/443 дугаар захирамж гарган “Цэвэр- Ногоон – Өлгий” аяныг 2 үе шаттайгаар зохион байгуулж ажиллав. Аяны хүрээнд аймгийн хэмжээнд нийт 36232 ширхэг мод таригдсан. “Грин Алтан ирээдүй” ойн мэргэжлийн байгууллага нь Сагсай сумын нутаг дэвсгэрт 10 га талбайд ойжуулалтын ажил хийж гүйцэтгэсэн. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний нээлтийг тус аймагт зохион байгуулан, энэ үеэр 41 байгуулага, ахуй нэгж, хувь иргэдийн оролцоотойгоор 8 төрлийн 10000 модыг цэцэрлэгт хүрээлэнгүүдэд тарив.	
7.7	Хавар, намрын хуурайшилт ихтэй	Сумдын ЗДТГ	Байгаль хамгаалагчда	Ой хээрийн түймрээс	Хавар, намрын хуурайшилт	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх,	100%

	үед ой, хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх сурталчилгааг мэдээллийн бүхий л хэрэгслээр ард иргэдэд хүргэх.	БОАЖГ	д хариуцсан нутаг дэвсгэртээ тавих хяналтаа сайжруулана	урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгаврыг сумдад хүргүүлсэн	ихтэй үед ой, хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх	хамгаалах тухай Улсын онцгой комиссийн 2021 оны 03-р сарын 01-ний өдрийн 02 тоот албан даалгаварын хүрээнд зохион байгуулах зарим арга хэмжээний төлөвлөгөө гаргаж сумдад хүргүүлж албан даалгаварын хүрээнд хавар намрын хэт их хуурайшилттай үед ойгоос мод бэлтгэх, ойн дагалт нөөц ашиглах, аялал зугаалгыг хязгаарлах, сум орон нутгийн аж ахуй нэгж албан байгууллага, ойн нөхөрлөл, иргэдэд түймэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар ухуулга, сурталчилгаа зохион байгуулаж боршуур тарааж ажиллаж байна. Байгаль хамгаалагчдад хариуцсан нутаг дэвсгэртээ тавих хяналтаа сайжруулах, эргүүл хяналт шалгалтын ажлаа эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажиллаа.	
8. **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**							
8.1	Аймгийн хэмжээнд жил		Тус аймгийн хэмжээнд	2019 онд 6000 гадаад,	Аялал жуулчлал тогтвортой	2021 онд “Ковид-19” цар тахалын улмаас гадаад	

	бүр аялсан гадаад, дотоод жуулчдын тоон мэдээлэлийг цуглуулж, боловсруулалт хийж, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.		гадаад дотоод аялагчдын 2010-2021 оны мэдээллийг цуглуулна.	2020 онд 25мянга дотоод жуулчин ирсэн.	хөгжиж, салбарын оролго нэмэгдэж жуулчдын тоо өссөн байна.	жуулчид ирээгүй боловч дотоодын жуулчидын тоо 2021 онд 30 мянгад хүрч, УБ хотын үндэсний радиогоор 1 удаа, МНВ-телевизээр 1 удаа, Орон нутгийн хэвлэл мэдээлэлээр 4 удаа аялал жуулчлалын салбарын сурталчилгааны ажлыг зохион байгуулав.	100%
8.2	Улаанбаатар хотод “Бүргэдийн баяр эвент арга хэмжээг зохион байгуулах”	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Жуулчдын тоо нэмэгдсэн байна.	Ковид-19 цар тахалын улмаас хойшлогдсон		Ковид-19 цар тахалын улмаас цуцлагдсан.	30%
8.3	“Бүргэдчдийн зөвлөгөөн зохион байгуулах	2.0	Аялал жуулчлалын мэдээллийн төв үйл ажиллагаа жигд явагдсан байна.	Ковид-19 цар тахалын улмаас хойшлогдсон		“Бүргэдчдийн анхдугаар чуулган”-ыг 2021 оны 10-р сарын 20-ний өдөр ЗАСХТ, Номадик экспедшинс, ХХК-тай хамтран аймгийн сум тус бүрээс Ахмад, дунд, залуу үеийн төлөөллүүд 140 гаруй бүргэдчдийг хамруулж, Бүргэдчдийн анхдугаар чуулганыг зохион байгуулав.	100%
8.4	“Бүргэдийн баяр” эвент зохион байгуулах	БОАЖЯамны санхүүжилтээр	Гадаад, дотоодын жуулчдын тоог 50 хувиар	2019 онд 3500 хүн оролцсон.	Гадаад дотоодын жуулчдын тоо нэмэгдсэн байна.	“Бүргэдийн баяр-2021” эвент арга хэмжээг зохион байгуулах аймгийн ЗДарын 2021 оны 11-р сарын 10-ны өдрийн А938 захирамж	100%

			нэмэгдүүлсэн байна.			гарч, ажлыг хэсэг байгуулж, хөтөлбөр, санхүүгийн тооцооллыг гарган, 22 дахь жилдээ 2021 оны 12-р сарын 04,05-ний өдрүүдэд 140 гаруй бүргэдчид оролцуулж, амжилттай зохион байгуулав. Эвент арга хэмжээнд Соёлын яамны нарийн бичгийн дарга Оюунбилэг, Төв аймгийн Монгол, залуу бүргэдчин Энхбилэг нар оролцов.	
8.5	"Ай Ти Эм" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлалын компаниуд болон иргэдийг оролцуулах	1.6	5-аас дээш аж ахуйн нэгж хамрагдсан байна.	2020 онд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 9 аж ахуйн нэгжүүдийг хамааруулж ажиллав.	Аялал жуулчлалын компаниудын төлөөлөл нэмэгдсэн байна	“ITM-2021” олон улсын үзэсгэлэн УБхотын Мишээл экспо төвд 2021 оны 10-р сарын 28,30-ний хооронд 3 хоног зохион байгуулагдаж, Талбайн түрээсний мөнгө 1.404.000 төгрөгийг 3Даргын нөөц хөрөнгөнөөс гаргуулж “ITM-2021” олон улсын үзэсгэлэнд аймгаа төлөөлж 11 ААНБайгууллагыг оролцуулан, аймгийн аялал жуулчлалыг сурталчилах ажлыг зохион байгууллаа.	100%
8.6	What3words цахим хаягжилтын		Монгол Улсын аялал жуулчлалын	What3words цахим хаягжилтын	Мэдээлэл сайтай болсон байна.	Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, ААНэгж	

	системийг аймаг орон нутгуудад нэвтрүүлж аялал жуулчлалын зорин очих газрын мэдээлэл, аж ахуй нэгжүүдийн хаягийг тус системд бүртгүүлэх, системийг нэвтрүүлэхэд шаардлагатай сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах		салбарыг цахимжуулах үйл ажиллагааг дэмжих, Гадаад дотоодын жуулчдын аюулгүй байдлыг хангах, сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн байна.	системийг орон нутагт зохион байгуулан ажилласан.		байгууллагыг What3words цахим хаягжилтын системийг сурталчилж, https: www.ihotel.mn, www.joinmee.mn сайтуудад нэгдүүлэн, аялал жуулчлалын чиглэлийн 20 гаруй ААНБайгууллагыг хамруулж, орон даяар аяллын зорин очих, газрын мэдээллийг байршуулж, сурталчилах ажлыг зохион байгуулсан.	100%
8.7	“Алтайн нүүдэлчид” арга хэмжээ зохион байгуулах	Аялал жуулчлалын компаниудын санхүүжилтээр	Гадаад, дотоодын жуулчдын тоог 5- иар нэмэгдүүлсэн байна. 6 сумын аялал жуулчлал эрхэлдэг 30 гаруй аж ахуйн нэгж,	Ковид-19 цар тахалын улмаас хойшлогдсон		Ковид-19 цар тахалын улмаас цуцлагдсан.	30%

			байгууллагыг оролцуулсан байна.				
9. Байгууллагын стратеги төлөвлөгөө, зорилт чиг үүргийн хүрээнд хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, сурталчилах, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, удирдлагыг бодит мэдээ, мэдээллээр хангах.							
9.1	Төрийн жинхнэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.		Төрийн жинхнэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталагдаж, хэрэгжсэн байна.	Байгууллагын албан хаагч нарт гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээ газрын даргад баталуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.	Төрийн жинхнэнэ албан хаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөгний хэрэгжилт биелэгдсэн байна.	Байгууллагын жинхэнэ албан хаагч нарын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр дүгнэж, төрийн үйлчилгээний албан хаагч нарын хөдөлмөрийн гэрээг жилээр дүгнэж ажиллаа.	100%
9.2	Хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж биелэлт, үр дүнг тооцож ажиллах.	Байгуулгын төсвөөр	Хүний нөөцийн ил тод байдлыг хангагдсан байна.	Хүний нөөцийн ил тод байдлыг цахим хуудасанд байрлуулж шинээр гарсан 3 сул орон тоонд төрийн албаны хуулийн дагуу захиалга өгөх, арга	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Хүний нөөцийн ил тод байдлыг цахим хуудасанд байрлуулж шинээр гарсан 3 сул орон тоонд төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэн, тусгай шалгалтанд тэнцсэн 2 байгаль хамгаалагч, 1 мэргэжилтэнийг хуулийн дагуу томилж, төрийн албаны салбар зөвлөлд хариу хүргүүлэн ажиллаа.	100%

				хэмжээ авч ажиллаж хүний нөөцийн программ хагас бүтэн жилээр төрийн албан хаагчийн судалгааг хугацаанд бүрэн оруулав.			
9.3	Байгууллагын тухайн жилийн бүтэц орон тоо, цалингийн хэмжээ ээлжийн амралтын хувиарыг тогтоох, баталуулах.	Байгуулгын төсвөөр	Батлаглсан орон тоо төсөвт багтаан үйл ажиллагаа явуулж, ажилчдын ээлжийн амралтын хувиарын дагуу амруулах, арга хэмжээ авагдсан байна.	2020 онд батлагдсан төсөв, орон тоонд багтаан ажилласан ба ажилчдын ээлжийн амралтын хувиарын дагуу бүрэн ээлжийн амралтыг эдэлүүлсэн	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна	2021 онд батлагдсан төсөв, орон тоонд багтаан ажилласан ба ажилчдын ээлжийн амралтын хувиарын дагуу бүрэн ээлжийн амралтыг биееэр нь эдлүүлэв.	100%
9.4	Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл,	Байгуулгын төсвөөр	БОАЖЯам болон төсөл хөтөлбөр, орон нутгаас зохион	Байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн	Төрийн албан хаагч нарын мэдлэг дээшлэгдсэн байна.	2021 онд сумдын байгаль хамгаалагч нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааны хүрээнд орон	100%

	нийгмийн баталгаа хангахад чиглэгдсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах		байгууллагдах сургалт семнарт холбогдох төрийн албан хаагч нарыг оролцуулсан байна.	асуудлыг шийдвэрлэж 5,ш ширээ,10 ш сандалаар хангаж ажиллах нөхцөл боломжийг сайжруулав.		нутгийн төсвөөс 10.0 сая төгрөг шийдвэрлүүлэн Алтанцөгц, Баяннуур, Буянт, Дэлүүн сумдын байгаль хамгаалагч нарын албан хэрэгцээнд нь зориулсан мотоциклээр хангасан.	
9.5	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэр дүрэм, жухам, стандартыг хэрэгжүүлэн ажиллах	Байгуулгын төсвөөр	Сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулагдсан байна.	Төрийн албан хаагч нарт 2 удаа сургалт зохион байгуулсан.	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэр дүрэм, жухам, стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын албан хаагч нарт 2 удаа сургалт зохион байгуулж сумдын байгаль хамгаалагч нарын ажил үүргийн гүйцэтгэгэж байх хугацаанд ХАБЭА тухай хууль, төрийн албаны тухай хууль, хөдөлмөрийн тухай хуулиудыг чанд биелүүлэх талаар мэргэжлийн арга зүйн зааварчилага өгч ажиллаа.	100 %
9.6	Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө		2020 онд албан тушаалтны 2019 оны хувийн ашиг сонирхлын	Байгууллагын ХАСХОМ гаргах 2 албан тушаалтныг хөрөнгө	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	2021 онд албан тушаалтны 2020 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө оролгын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргаж	100%

	оролгын мэдүүлгийг хууль заасан хугацаанд гаргуулах.		мэдүүлэг болон хөрөнгө оролгын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулсан байна	оруулгын мэдүүлгийг хугацаанд гаргаж баталгаажуулсан байна.		холбогдох газарт нь хүргүүлж ажиллаа.-+	

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Төлөвлөгөөг хянасан: ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

.... /...../

(албан тушаал) (гарын үсэг)

(огноо)

Тэмдэг .....

Төлөвлөгөө тайлагнасан: ***Төсвийн Шууд захирагч***

.... /...../

(албан тушаал) (гарын үсэг)

(огноо)

Тэмдэг .....